

САНАЛЫН ТОВЪЁОГ

“Чөлөөт бүсэд мөрдөх журам”-ын төслийг 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрөөс 05 дугаар сарын 27-ны өдрийг дуустал 30 хоногийн хугацаанд Эдийн засаг, хөгжлийн яамны <https://med.gov.mn/>, Замын-Үүд чөлөөт бүсийн <http://zfz.gov.mn> цахим сайтанд байршуулан олон нийтээс санал авсан ба мөн эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх иргэн, хуулийн этгээдийн төлөөлөл “Алтанбулаг”, “Замын-Үүд”, “Цагааннуур” чөлөөт бүсүүдэд хөрөнгө оруулагч, иргэн, аж ахуй нэгжүүдийн төлөөллүүдээр хэлэлцүүлэн санал авах ажиллагааг 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт Эдийн засаг, хөгжлийн яамны Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газар, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Гаалийн ерөнхий газар болон холбогдох албаны хүмүүс оролцов.

Дээрхи ажлын хүрээнд дараах саналуудыг ирүүлсэн байна.

№	Санал гаргасан Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн нэр	Дэмжсэн эсэх	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан эсэх	Тайлбар
1	Цахим хөгжил, харилцаа, холбооны яам	Дэмжсэн	Журмын төсөлтэй холбоотойгоор тус яамнаас шаардлагатай чөлөөт бүсэд нэвтрэх систем болон холбогдох ажлууд дээр дэмжин хамтран ажиллахад бэлэн гэдгээ илэрхийлсэн.	-	-
2	Гаалийн ерөнхий газар	Дэмжсэн	Журмын төсөлд санал өгсөн. Зөвхөн Замын-Үүд чөлөөт бүс дээр мөрдөгдөх журам гэж буруу ойлгоцон санал өгсөн ч	-	-

			гаалийн тусгай дэглэм нь Гаалийн тухай хууль, Чөлөөт бүсэд горим хэрэгжүүлэх журам болон бусад холбогдох хууль журмын дагуу чөлөөт бүсүүдэд нэгдсэн нэг ижил зохицуулалтаар хэрэгжинэ.		
3	Ч.Амарбаатар /Алтанбулаг, Замын-Үүд чөлөөт бүсэд хөрөнгө оруулагч/	Дэмжсэн	Журмын 3.6-д туссан “Хөрш улстай хэлэлцээрийн дагуу байгуулсан бүс хооронд тээврийн хэрэгслийг хилийн гарцаар хоёр талын хэлэлцээрт заасан баримт бичгээр нэвтрүүлнэ.” гэдэг нь Монгол, Хятад Замын-Үүд, Эрээний эдийн засгийн хамтын ажиллагааны бүс байгуулах тухай хэлэлцээртэй хэрхэн уялдаж байгааг тодруулсан. Цаашид тээврийн хэрэгслийг хилийн гарцаар нэвтрүүлэхэд хялбаршуулан цөөн бичиг баримт шаардх тал дээр анхаарах.	Саналыг тусгаагүй. Цаашид анхааран ажиллах.	Чөлөөт бүсийн тухай хууль болон журмын төслийн гуравдугаар зүйлд чөлөөт бүсэд бараа тээврийн хэрэгслийг нэвтрүүлэхэд хялбарчилсан бүрдүүлэлт хийхээр заасан ба хэлэлцээрийн 5 дугаар зүйлийн 5.5.-д “Талууд хамтын ажиллагааны бүсэд орж гарах зорчигч тээврийн хэрэгслийн бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтыг хялбаршуулах талаар боломжит бүх арга хэмжээг авна”-гэсний дагуу Хамтын ажиллагааны бүсийн Хамтарсан гүйцэтгэх, Хамтарсан зохицуулах зөвлөлөөр ахин хэлэлцэгдэх асуудал юм.
		Дэмжсэн	Журмын 8.2.6-д заасан . “чөлөөт бүсийн ажиллах цагийн хуваарь, бүтээн байгуулалтын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, хуулийн этгээдийн ажиллах цагийн хуваарийг тухайн чөлөөт	Саналыг тусгаагүй.	Журмын төсөлд туссан.

			бүсийн харуул хамгаалалтын үүргийг гүйцэтгэж байгаа хилийн мэргэжлийн байгууллагуудтай зөвшилцөн чөлөөт бүсийн Захирагчийн ажлын алба тус тус тогтооно.”-гэснийг дэмжсэн.		
		Дэмжсэн	Журмын 10.2-т заасан “Чөлөөт бүсийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан чөлөөт бүсэд аялал жуулчлал, төлбөрт таавар, бооцоот тоглоомын үйл ажиллагаа явуулах, банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд тухайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Монгол Банктай байгуулсан гэрээний дагуу зохицуулна.”-гэснийг анхаарах. Монгол банк гэрээ байгуулах эсэх. Төрийн захиргааны төв байгууллага нь эрх мэдлээрээ шийдвэрлэдэг байх шаардлагатай.	Саналыг тусгаагүй.	Чөлөөт бүсийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.-т “Чөлөөт бүсэд банк, банк бус санхүүгийн байгууллага, түүний салбар нэгж байгуулахтай холбогдсон харилцааг холбогдох хуулиар зохицуулна.”, 17 дугаар зүйлд “чөлөөт бүс дэх тусгай дэглэмийн болон бусад үйлчилгээний зохицуулалтыг тухайн асуудал хариуцсан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн дээр хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан тул Төрийн захиргааны төв байгууллага болон Монгол банктай байгуулсан гэрээний дагуу зохицуулахаар төсөлд тусгасан тул саналыг нэмэх боломжгүй гэж үзсэн.
4	Н.Алтангэрэл /Замын-Үүд чөлөөт бүсэд	Дэмжсэн	Журмын 3.2.2-т заасан “Монгол Улсын нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд	Саналыг тусгаагүй.	Чөлөөт бүсийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1-д.”хилийн чанадаас чөлөөт бүсэд оруулах бараанд ачааны

	хөрөнгө оруулагч/		оруулах бараанд энэ журмын 3.2.1-д заасан баримт бичгээс гадна татвар төлсөн баримт.” шаардана гэснийг тодорхой болгох шаардлагатай.		манифест, тээврийн баримт бичиг, шаардлагатай тохиолдолд холбогдох зөвшөөрөл, лиценз;”, 10.1.2.-т “Монгол Улсын нутаг дэвсгэрээс чөлөөт бүсэд оруулах бараанд энэ хуулийн 10.1.1-д заасан баримт бичгээс гадна татвар төлсөн баримт.”, мөн Гаалийн тухай хуулийн 231 дүгээр зүйлийн 231.2-т “Чөлөөт бүсийн төрөл, тавигдах шаардлага, татварын асуудлыг Чөлөөт бүсийн тухай хуулиар зохицуулна” гэж тус тус заасан тул саналыг тусгах боломжгүй тодорхой гэж үзсэн.
5	н.Туяа /Алтанбулаг чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч/	Дэмжсэн	Чөлөөт бүсийн ажиллах цагийн хуваарийг уртасгах. Гаалийн байгууллагын ажилтны үйл ажиллагааг хялбаршуулах шаардлагатай.	Саналыг тусгаагүй.	Журмын төсөлд холбогдолгүй.
6	н.Өлзийбаяр /Алтанбулаг чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч/	Дэмжсэн	Журмын төсөлд нэр томъёоны тайлбар нэмэх саналтай байна.	Саналыг тусгаагүй.	Журмын төсөлд тусгагдсан нэр томъёо тухайлбал “ачааны манифест” нь Гаалийн тухай хууль, Чөлөөт бүсийн тухай хуульд туссан нэршил, мөн Гаалийн ерөнхий газрын даргын 2019 оны А/281 дүгээр тушаалаар баталсан “Ачааны манифест нөхөн бичих, хянах, бүртгэх журам”-ыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн баталсан тул төсөлд тайлбар нэмэх шаардлаггүй гэж үзсэн.
			Журмын 5.5-д заасан 5.5. “Улсын хилийн зурваст	Саналыг тусгаагүй.	Чөлөөт бүсийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5.1-т.

			байгуулсан чөлөөт бүсэд үйл ажиллагаа явуулах иргэн, хуулийн этгээд аж ахуйн үйл ажиллагааны чиглэл болон тусгай зөвшөөрөл авах гэрээнд заасан үйл ажиллагаагаа эхлүүлээгүй нөхцөлд газар ашиглах эрхээ бусдад шилжүүлэхийг хориглоно.” Гэсэн заалт дээр уян хатан хандах байдлаар оруулах.		”хөрөнгө оруулалтын гэрээ байгуулж, чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлийн гэрчилгээ олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд гэрээ, дүрэмд заасан үндсэн үйлдвэрлэл, үйлчилгээг эхлүүлээгүй;” тохиолдолд чөлөөт бүс дэх хуулийн этгээдийн бүртгэлээс хасахаар заасан.
7	Глобал гров чөлөөт бүс ХХК /Замын-Үүд чөлөөт бүсийн хөрөнгө оруулагч/	Дэмжсэн	Журмын төслийн 5.1-5.5 дахь зүйл нь хуулийн заалтуудтай давхардаж байна.	Саналыг тусгаагүй.	Чөлөөт бүсийн тухай хууль шинэчлэн батлагдсанаар чөлөөт бүсэд үйл ажиллагаа эрхлэх иргэн, хуулийн этгээдийг бүртгэх, чөлөөт бүсэд зорчигч, бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх, чөлөөт бүсээс барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах болон газрын харилцааны зохицуулалт зэргийг хамруулсан нийтлэг журмыг хууль тогтоомжийн хүрээнд батлан мөрдүүлэх хэрэгцээ шаардлага бий болсон. Энэхүү журам нь чөлөөт бүсэд мөрдөгдөх тусгай дэглэмүүд болон үйл ажиллагааг нарийвчилан зохицуулах зорилготой.
			Журмын төслийн 5.5-т заасан үйл ажиллагаагаа эхлүүлээгүй бол үйл	Саналыг тусгаагүй.	Газрын тухай хуулийн 22 ¹ дүгээр зүйл.Чөлөөт бүсийн захирагчийн бүрэн эрх, 22 ¹ .1.-т

			ажиллагааны чиглэлээ өөрчлөх боломжтой байдлаар оруулах саналтай байна.		“Чөлөөт бүсийн батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу чөлөөт бүсийн газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлж ашиглуулах асуудлыг шийдвэрлэж, зохион байгуулна.”, Чөлөөт бүсийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.-т “Чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газар батална.”, “24.2-т “Энэ хуулийн 24.1-д заасан ерөнхий төлөвлөгөөний дагуу чөлөөт бүсийн хот байгуулалт, дэд бүтэц, барилга байгууламжийг барьж байгуулахтай холбогдсон харилцааг Хот байгуулалтын тухай, Барилгын тухай, Авто замын тухай, Эрчим хүчний тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжоор зохицуулна.” гэж тус тус заасан тул чөлөөт бүсэд газар ашиглах эрхтэй аж ахуй нэгж нь үйл ажиллагааны чиглэлээ өөрчлөх боломжгүй тул саналыг тусгаагүй.
8	н.Мижидсүрэн	Дэмжсэн	Журмын төслийг дэмжиж байна. Журмын төсөл дээр Эрдэмтэн, судлаачдын баг ажиллуулах саналтай байна.	-	-

9	ЭЗХЯ н.Ган-Эрдэнэ	Дэмжсэн	Журмын төслийн 3.4.1-д заасан 3.4.1. Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, хил орчим зорчих үнэмлэх; гэснийг эсхүл гэж зааглан ангилах.	Саналыг тусгасан	Журмын төслийн 3.4.1-д заасан 3.4.1. Иргэний үнэмлэх, үндэсний гадаад паспорт, хил орчим зорчих үнэмлэх; гэснийг эсхүл гэж нэмж тусгасан.
---	----------------------	---------	---	------------------	---

---oOo---